

2019 ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД УЛСЫН ХЭМЖЭЭНД БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙН ТООН ҮЗҮҮЛЭЛТ, ТАНИЛЦУУЛГА


2019.04.02

Улаанбаатар хот

Нэг.ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ДУУДЛАГА, БҮРТГЭГДСЭН ОСОЛ


Улсын хэмжээнд зам тээврийн ослын шинжтэй дуудлага 17225-г хүлээн авч шийдвэрлэсэн байна. Зам тээврийн ослын шинжтэй дуудлагын тоо нь өнгөрсөн оны үзүүлэлтээс улсын хэмжээнд 7.1 хувиар, Улаанбаатар хотод 7.7 хувиар тус тус статистик мэдээгээр буурсан үзүүлэлт гарч байна.

ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА



Зам тээврийн ослын дуудлагын 95.6 хувь нь нийслэлд ирүүлсэн дуудлага мэдээлэл, 4.4 хувь нь орон нутгийн цагдаагийн газар, хэлтэст ирүүлсэн дуудлага мэдээлэл эзэлсэн байна. Улсын хэмжээнд 6415 зам тээврийн осол бүртгэгдсэний 5688 буюу 88.7 хувь нь нийслэлд, 11.3 хувь нь орон нутгийн замд бүртгэгджээ. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад нийслэлд осол 7.1 хувиар буурч, орон нутагт 8.7 хувиар өсчээ.

БҮРТГЭГДСЭН ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ




Орон нутагт бүртгэгдсэн осол 18.4% өссөн, 2 дугаар их осол бүртгэгдсэн.

Өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад: зам тээврийн осол улсын хэмжээнд буурсан ч орон нутагт 18.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хоёр.ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АШИГЛАЛТЫН ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

Улсын хэмжээнд 2019 оны эхний 3 сарын байдлаар нийт 9905 гэмт хэрэг бүртгэгдсэний дотор Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 328 буюу 3.3 хувийг эзэлж байна. /хувийн жин 0.6 хувиар өссөн/

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг



Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг улсын хэмжээнд 12.7, нийслэлд 29.6 тус тус өсч, орон нутагт 1.9 хувиар өсчээ.

Энэ төрлийн гэмт хэргийн улмаас улсын хэмжээнд 75 хүн нас барж, 263 хүн гэмтсэн статистик үзүүлэлт гарсан ч бодит нас баралт 96-д хүрсэн.


Улсын хэмжээнд бүртгэгдсэн Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн 53.4 хувь нь нийслэлд, 46.6 хувь нь орон нутагт бүртгэгджээ. Гэмт хэрэг Говь-Сүмбэр 4 дахин, Баян-Өлгий 3 дахин, Булган 2 дахин, Төв аймаг 92.3%, Орхон 80%, Архангай аймагт 66.7%, Хөвсгөл, Завхан, Баянхонгор аймгуудад тус тус 50.0%, Сэлэнгэ 40.%, хувиар, нийслэлийн бүх дүүрэгт 14.3-50.0 хүртэл хувийн өсөлттэй.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих /ЭХ 27.1-27.3/ заалтаар 2019 оны эхний 3 сарын байдлаар 3 гэмт хэрэг үүсгэгдэн шалгагдсан байна.

Гурав. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 96 хүн нас барж /бодит нас баралтын тоо/, 699 хүн гэмтэж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 6,6 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 75 хүн нас барж, 263 хүн гэмтсэн байна.


НАС БАРСАН ХҮН:



Улсын хэмжээнд хүний амь нас хохирсон Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг ЭХХШТХуулийн 1.5.1.1 /32.5.1.1/ дэх заалтаар 20 хэрэг хэрэгсэхгүй болж статистик мэдээнээс хасагдсан учир улсын хэмжээний гэмт хэргийн мэдээнд нас барсан хүний тоо 75 хүнээр тусгагдсан байна.

Нийслэлийн хэмжээнд 2019 оны эхний 3 сарын байдлаар зам тээврийн ослын улмаас 24 /бодит/, гэмт хэргийн улмаас 20 хүн амь насаа алдсан үзүүлэлт гарч байна.

Хүний амь нас хохирсон ослын улмаас 96 хүний амь нас хохирсон үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад 10.3 хувиар өссөн үзүүлэлт гарч байна.




Өсөлт, бууралтыг төв, орон нутгаар авч үзвэл: Орон нутагт Орхон, Сүхбаатар аймгуудад 5 дахин, Архангай аймагт 4 дахин, Дорноговь аймагт 3 дахин, Говь-Алтай аймагт 2 дахин, Сэлэнгэ аймагт 33.3%, нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт 66.7%-ийн өсөлттэй байна. Дархан-Уул 50.0%, Дундговь 33.3%, Өвөрхангай 66.7%, Өмнөговь 71.4%, Ховд 75.0%, Хэнтий 83.3%, Төв 10.0%, нийслэлийн Хан-Уул дүүрэгт 60.0%, Сүхбаатар дүүрэгт 16.7%-иар буурчээ.

ГЭМТСЭН ХҮН:



Улсын хэмжээнд зам тээврийн ослын улмаас 699 хүн эрүүл мэндээрээ хохирсоны 263 нь хүнд, хүндэвтэр зэргийн гэмтэл, 436 нь хөнгөн зэргийн буюу тодорхой хэмжээний гэмтэл, бэртэл авсан байна. Өөрөөр хэлбэл 699 гэмтэл авсан хүний 263 нь хүнд, хүндэвтэр гэмтэл авч эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагджээ.



Гэмт хэргийн улмаас 160 буюу 60.8 хувь нь нийслэлд, 103 буюу 39.2 хувь нь орон нутагт хүнд, хүндэвтэр гэмтэж хохирсон байна.



Зам тээврийн ослын улмаас гэмтэл авсан хүний 510 буюу 72.9 хувь нь нийслэлд үйлдэгдсэн зам тээврийн ослын улмаас, 27.1 хувь нь орон нутгийн замд үйлдэгдсэн ослын улмаас гэмтэл, бэртэл авсан байна.




Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 96 хүн /бодит/, гэмтсэн 699 хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрийг авч үзвэл:

Улсын хэмжээнд:

- Явган зорчигч – 26 хүн амь насаа алдаж, 395 гэмтсэн

- **Жолооч** – 38 хүн амь насаа алдаж, 55 гэмтсэн
- Тээврийн хэрэгслээр зорчигч – 32 хүн амь насаа алдаж, 245 гэмтсэн
- Дугуйтай хүн – 4 гэмтсэн




Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан, гэмтэж бэртсэн хүний замын хөдөлгөөнд оролцож байсан хэлбэрээс авч үзвэл: Нийслэлд амь насаа алдсан хүний 70.8 хувийг ЯВГАН ЗОРЧИГЧ, орон нутагт тээврийн хэрэгслийн ЖОЛООЧ 50.0 хувийг эзэлсэн байгаа нь нийслэлд явган зорчигч, орон нутагт жолооч амь нас, эрүүл мэндээрээ хохирч байна.

Дөрөв. **ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРСОН ОСОЛ** /Гэмт хэрэг/

Хүний амь нас хохирсон зам тээврийн осол 88 бүртгэгдэж 96 хүний амь нас хохирчээ. Үзүүлэлтийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад хүний амь нас хохирсон ослын тохиолдол 10.0 хувиар, амь насаа алдсан хүний тоо 10.3 хувиар өсчээ. Амь насаа алдсан хүний 75.0 хувь нь орон нутагт, 25.0 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.






Хүний амь нас хохирсон ослын гаралт:

ӨССӨН:

- СҮХБААТАР аймагт 5 дахин
- АРХАНГАЙ аймагт 4 дахин
- ОРХОН аймагт 4 дахин
- ДОРНОГОВЬ аймагт 2.5 дахин
- СЭЛЭНГЭ аймагт 33.3 хувь
- БАЯНЗҮРХ дүүрэг 25.0%
- СОНГИНОХАЙРХАН дүүрэг 50.0%




Улсын хэмжээнд 2 ба түүнээс дээш хүний амь нас хохирсон осол бүртгэгдсэн ба газар дээрээ 3 хүний амь нас хохирсон осол 1 удаа, 2 хүний амь нас хохирсон осол 6 удаа бүртгэгдсэн байна.



Хүний амь нас хохирсон осол 2019 оны эхний улирлын байдлаар 3 дугаар сард хамгийн их бүртгэгдэж, өдрийн цагт хүний амь нас хохирсон ослын 76,1% нь гарчээ.

Хүний амь нас хохирсон осол 06.00-14.00 цагт 110 буюу 29.4 хувь, 14.00-19.00 цагуудад 121 буюу 32.4 хувь, 19.00-22.00 цагуудад 71 буюу 19.0 хувь, 22.00-06.00 цагуудад 72 буюу 19.3 хувь нь тус тус бүртгэгджээ.

ХҮНИЙ АМЬ НАС ХОХИРСОН ОСЛЫН ШАЛТГААН НӨХЦӨЛ



Улсын хэмжээнд бүртгэгдсэн хүний амь нас хохирсон ослын шалтгаан нөхцлөөс харахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос 30.3%, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан осол 35.2%, хурд хэтрүүлсэнээс 23.8% нь тус тус бүртгэгджээ.

Хүний амь нас хохирсон ослын 43 буюу **48.8%** нь ОНХОЛДОХ, 11 буюу 12.5 хувь нь мөргөлдөх, 29 буюу 33.0 хувь нь явган зорчигч мөргөх, 5.7% нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн.

Тав. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ШАЛТГААН


Улсын хэмжээнд бүртгэгдсэн 6415 зам тээврийн ослын 6165 буюу 98.6 хувь нь жолоочийн буруугаас, 82 буюу 1.3 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, замын нөхцөл байдлаас 5 буюу 0.1 хувь нь бүртгэгджээ.

№	ШАЛТГААН	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Жолоочийн буруутай үйлдэл	6155	98.6	5638	98.9	527	95.1
2	Явган зорчигчийн буруутай үйлдэл	82	1.3	57	1.0	25	4.5
3	Замын нөхцөл	5	0.1	3	0.0	2	0.4




Тайлангийн хугацаанд цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сангийн Өргөдөл гомдлын санд орон нутгаас оруулсан зам тээврийн ослын мэдээлэл зөрүүтэй гарсан тул осол гарсан шалтгаан нөхцлийн мэдээ 163 ослоор зөрж гарсан.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын шалтгааны 98.6 хувь нь жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалсан ба хажуу хоорондын зай тохируулаагүй, уулзвар гарц нэвтрэх журам зөрчсөн, эгнээ байр буруу эзэлсэн, ухрах үйлдэл, хурд хэтрүүлсэн, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол дийлэнх хувийг эзэлсэн байна.



Зам тээврийн ослын шалтгаан дотроос хамгийн их хор уршиг учруулдаг шалтгаан нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодох, хурд хэтрүүлэх тохиолдол байдаг. Зам тээврийн осол гарсан шалтгааныг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан авч үзэхэд: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсоноос шалтгаалсан осол 0.1 хувиар, хурд хэтрүүлсэнээс үйлдэгдсэн осол 0.2 хувиар өссөн үзүүлэлт гарч байна.



Согтуугаар үйлдэгдсэн осол Дорноговь, Орхон, Увс аймгуудад давамгайлсан байхад нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт бусад дүүргээс их бүртгэгдсэн байна.

Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын хувьд улсын хэмжээнд 82 бүртгэгдсэн нь нийт ослын 1.3%-г эзэлсэн байна. Явган зорчигчийн өөрсдийн буруутай үйлдлээс шалтгаалсан осол нийслэлд 69.5% нь бүртгэгдсэн байна.



Явган зорчигчийн буруутай үйлдлээс шалтгаалсан зам тээврийн ослын 35 буюу 42.7 хувийг явган зорчигчийн өөрийн буруу, 5 буюу 6.1 хувийг эцэг, эх, асран хамгаалагчийн буруутай үйлдэл, 42 буюу 51.2 хувь нь явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос шалтгаалсан байна. Явган зорчигч согтуугаар замын хөдөлгөөнд оролцсоноос

зам тээврийн осолд өртөх нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 13.3 хувиар өссөн нь согтуугаар замын хөдөлгөөнд оролцогч явган зорчигч ихсэх хандлагатай байна.

Зургаа. ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ ГАРСАН ХЭЛБЭР

Улсын хэмжээнд бүртгэгдсэн зам тээврийн ослын 5433 буюу 86.8% нь мөргөлдөх, 406 буюу 6.5% нь явган зорчигч мөргөх, 145 буюу 2.3 хувь нь онхолдох, 222 буюу 3.6 хувь үл хөдлөх зүйл мөргөх /хашаа, хайс, гэр, орон сууц, шон мөргөсөн/, зорчигч унагах 14, дугуйтай хүн мөргөх 5, мал, амьтан дайрах 11 осол, 16 буюу 0.3 хувь нь бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

№	ХЭЛБЭР	УЛС	эзлэх %	ХОТ	эзлэх %	ОРОН НУТАГ	эзлэх %
1	Мөргөлдөх	5433	86.8	5113	89.7	320	57.7
2	Явган хүн дайрах	406	6.5	353	6.2	53	9.6
3	Үл хөдлөх зүйл мөргөх	222	3.6	193	3.4	29	5.2
4	Онхолдох	145	2.3	26	0.5	119	21.5
5	Мал, амьтан дайрах	11	0.2	2	0.0	9	1.6
6	Зорчигч унагах	14	0.2	7	0.1	7	1.3
7	Дугуйтай хүн мөргөх	5	0.1	4	0.1	1	0.2
8	Бусад	16	0.3	0	0.0	16	2.9



Зам тээврийн осол гарсан хэлбэрээс авч үзвэл: ОНХОЛДОХ хэлбэрээр бүртгэгдсэн ослын 82.0% нь ОРОН НУТАГТ бүртгэгдсэн байхад ЯВГАН ЗОРЧИГЧ мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн ослын 86.9% нь НИЙСЛЭЛД тус тус бүртгэгджээ.